ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/06/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 10
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 13
3.4 Материаллаг байдал 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15
3.8 Аудитын гол асуудал 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд....16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт 16
4.1 Залруулсан алдаа 17
4.2 Төлбөрийн акт 17
4.3 Албан шаардлага 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/705

танай _____-ны № _____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх хийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн олон жилийн насжилттай, тооцоо нийлээгүй авлагын үлдэгдэлтэй, урьдчилж орсон орлогыг тайлант жил орлогоор хүлээн зөвшөөрөөгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон 32.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Иргэний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	14,547,221,918.18	16,898,380,949.77
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	125,694,901.39	3,809,313,009.23
31200	**Банкинд байгаа бэлэн мөнгө**	125,694,901.39	3,809,313,009.23
31210	**Төгрөг**	125,694,901.39	3,809,313,009.23
31211	Төрийн сангийн харилцах	125,694,901.39	3,809,313,009.23
33	**АВЛАГА**	814,131,594.79	1,635,108,000.54
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	814,131,594.79	1,601,604,400.75
33500	**Бусад авлага**	-	33,503,599.79
33510	Байгууллагаас авах авлага	-	33,503,599.79
35	**БАРАА МАТЕРИАЛ**	-	1,188,000.00
35400	**Хангамжийн материал**	-	1,188,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,188,000.00
360	**БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ**	13,607,395,422.00	11,452,771,940.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	13,607,395,422.00	11,452,771,940.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	9,386,103.84	7,841,834.54
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	9,386,103.84	7,841,834.54
39200	**Биет хөрөнгө**	8,045,074.58	7,027,155.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,600,000.00	34,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,055,723.80)	(34,515,723.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,670,200.00	13,135,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,797,279.60)	(6,570,606.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,607,985.94	4,173,554.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,980,107.96)	(3,795,167.98)
39300	**Биет бус хөрөнгө**	1,341,029.26	814,679.26
39301	Программ хангамж	5,131,750.00	2,631,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,790,720.74)	(1,817,070.74)
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	14,556,608,022.02	16,906,222,784.31
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	713,290,564.54	3,446,804,972.70
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	713,290,564.54	3,446,804,972.70
41300	**Өглөг**	126,755,579.70	362,178,583.24
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	5,067,488.00	130,669,434.30
41360	**Бусад өглөг**	121,688,091.70	231,509,148.94
41361	Байгууллагад төлөх өглөг	121,688,091.70	231,509,148.94
41400	**Урьдчилж орсон орлого**	586,534,984.84	3,084,626,389.46
41440	Бусад урьдчилж орсон орлого	586,534,984.84	3,084,626,389.46
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	13,843,317,457.48	13,459,417,811.61
51	**Засгийн газрын хувь оролцоо**	13,843,317,457.48	13,459,417,811.61
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	23,293,144.00	23,293,144.00
51200	**Хуримтлагдсан үр дүн**	13,812,422,193.83	13,428,522,547.96
51210	Өмнөх үеийн үр дүн	10,861,049,243.89	8,625,622,683.83
51220	Тайлант үеийн үр дүн	2,951,372,949.94	4,802,899,864.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,602,119.65	7,602,119.65
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	14,556,608,022.02	16,906,222,784.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	3,264,496,816.90	5,040,298,488.66
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	3,264,496,816.90	5,039,178,488.66
120	**Нийтлэг татварын бус орлого**	3,264,496,816.90	5,039,178,488.66
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	3,264,496,816.90	5,039,178,488.66
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,264,446,816.90	5,039,178,488.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	-
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	-	1,120,000.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	-	1,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,120,000.00
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	261,923,866.96	237,398,624.53
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	261,923,866.96	237,398,624.53
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	256,423,866.96	231,349,550.53
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	175,863,416.66	172,691,339.30
210102	Нэмэгдэл	152,631,416.66	149,459,339.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	23,232,000.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	23,737,726.40	22,244,980.32
210201	Тэтгэврийн даатгал	16,882,300.00	15,790,880.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	1,613,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,431,126.40	1,290,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	148,000.00	322,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	3,227,300.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	11,843,000.00	8,817,421.16
210401	Бичиг хэрэг	1,768,600.00	1,833,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,072,000.00	4,156,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,857,400.00	874,752.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,145,000.00	1,952,769.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,930,100.00	1,136,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	1,136,200.00
2107	**Томилолт, зочны зардал**	21,602,800.00	18,966,250.00
210702	Дотоод албан томилолт	20,345,500.00	18,966,250.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	-
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	4,999,852.00	1,517,890.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	764,914.45
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,752.00	69,776.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	645,000.00	572,000.00

2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	12,446,971.90	5,975,469.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,657,480.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,389,491.90	5,975,469.30
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	5,500,000.00	6,049,074.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	5,500,000.00	4,929,074.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	4,929,074.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	-	1,120,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,120,000.00
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	3,002,572,949.94	4,802,899,864.13
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	51,200,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	51,200,000.00	-
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	2,951,372,949.94	4,802,899,864.13

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	23,293,144.00	7,602,119.65	10,864,523,078.89	10,895,418,342.54
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	10,864,523,078.89	10,895,418,342.54
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(3,473,835.00)	(3,473,835.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	2,951,372,949.94	2,951,372,949.94
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	13,812,422,193.83	13,843,317,457.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(5,186,799,510.00)	(5,186,799,510.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	8,625,622,683.83	8,656,517,947.48
Тайлант үеийн үр дүн	-	-	4,802,899,864.13	4,802,899,864.13
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	13,428,522,547.96	13,459,417,811.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	4,408,235,905.46	6,842,108,605.32
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	4,408,235,905.46	6,840,988,605.32
120	**Нийтлэг татварын бус орлого**	4,408,235,905.46	6,840,988,605.32
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	4,389,858,398.86	6,750,340,079.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,982,040,362.20	6,750,340,079.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	337,126,044.15	-
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	70,641,992.51	-
120009	Бусад орлого	18,377,506.60	90,648,526.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	-	1,120,000.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	-	1,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,120,000.00
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	4,282,541,004.07	3,158,490,497.48
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	4,282,541,004.07	3,158,490,497.48
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	258,331,360.07	245,867,341.78
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	175,863,416.66	172,691,339.30
210102	Нэмэгдэл	152,631,416.66	149,459,339.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	23,232,000.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	23,737,726.40	22,244,980.32
210201	Тэтгэврийн даатгал	16,708,300.00	15,790,880.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	1,613,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,407,000.00	1,290,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	346,126.40	322,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	3,227,300.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	11,843,000.00	10,135,465.16
210401	Бичиг хэрэг	1,768,600.00	1,833,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,072,000.00	5,464,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,857,400.00	874,752.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,145,000.00	1,962,813.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,930,100.00	5,567,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	5,567,400.00
2107	**Томилолт, зочны зардал**	21,602,800.00	18,966,250.00
210702	Дотоод албан томилолт	20,345,500.00	18,966,250.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	-
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	4,999,852.00	4,165,156.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	3,412,180.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,752.00	69,776.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	645,000.00	572,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	14,354,465.01	12,096,751.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,954,465.01	12,096,751.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	-
212	**ТАТААС**	4,018,709,644.00	2,906,574,081.70
2122	**Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас**	4,018,709,644.00	2,906,574,081.70
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,018,709,644.00	2,906,574,081.70
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	5,500,000.00	6,049,074.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	5,500,000.00	4,929,074.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	4,929,074.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	-	1,120,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,120,000.00
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	125,694,901.39	3,683,618,107.84
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	125,694,901.39	3,683,618,107.84
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	125,694,901.39
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	125,694,901.39	3,809,313,009.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	3,932,048,400.00	3,145,273,746.48	786,774,653.52	80.0
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	3,932,048,400.00	3,145,273,746.48	786,774,653.52	80.0
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	244,964,800.00	233,770,590.78	11,194,209.22	95.4
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	175,876,800.00	172,691,339.30	3,185,460.70	98.2
210102	Нэмэгдэл	152,644,800.00	149,459,339.30	3,185,460.70	97.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	23,232,000.00	-	100.0
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	23,743,400.00	22,244,980.32	1,498,419.68	93.7
210201	Тэтгэврийн даатгал	16,708,300.00	15,790,880.32	917,419.68	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	1,613,400.00	145,400.00	91.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,407,000.00	1,290,800.00	116,200.00	91.7
210204	Ажилгүйдлийн даатгал	351,800.00	322,600.00	29,200.00	91.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	3,227,300.00	290,200.00	91.7
2104	**Хангамж, бараа материалын зардал**	11,843,700.00	10,135,465.16	1,708,234.84	85.6
210401	Бичиг хэрэг	1,871,100.00	1,833,900.00	37,200.00	98.0
210402	Тээвэр, шатахуун	6,072,000.00	5,464,000.00	608,000.00	90.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,600.00	874,752.16	1,045,847.84	45.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,980,000.00	1,962,813.00	17,187.00	99.1
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,930,100.00	5,567,400.00	362,700.00	93.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	5,567,400.00	362,700.00	93.9
2107	**Томилолт, зочны зардал**	21,602,800.00	18,966,250.00	2,636,550.00	87.8
210702	Дотоод албан томилолт	20,345,500.00	18,966,250.00	1,379,250.00	93.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	-	1,257,300.00	-
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	5,168,000.00	4,165,156.00	1,002,844.00	80.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	3,412,180.00	687,820.00	83.2
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	89,200.00	108,800.00	45.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	69,776.00	128,224.00	35.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	572,000.00	78,000.00	88.0
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	800,000.00	-	800,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	-	800,000.00	-

212	**ТАТААС**	3,681,583,600.00	2,906,574,081.70	775,009,518.30	78.9
2122	**Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас**	3,681,583,600.00	2,906,574,081.70	775,009,518.30	78.9
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,681,583,600.00	2,906,574,081.70	775,009,518.30	78.9
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	5,500,000.00	4,929,074.00	570,926.00	89.6
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	5,500,000.00	4,929,074.00	570,926.00	89.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	4,929,074.00	570,926.00	89.6
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	3,932,048,400.00	6,750,340,079.32	(2,818,291,679.32)	171.7
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	3,932,048,400.00	6,750,340,079.32	(2,818,291,679.32)	171.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,932,048,400.00	6,750,340,079.32	(2,818,291,679.32)	171.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50,629,867.29		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,655,696,200.13		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 05-наас 2022 оны 3 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх шинэчлэх зориулалтаар, үйлчилгээ явуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам” 4 дүгээр тушаал;
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дүгээр тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулж, баталгаажуулсан байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан дотоод хяналтын нэгжгүй боловч төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох

бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасан хяналтын үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хэрэгжүүлдэг боловч тайлант жил аудит хийгээгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 3,264.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 32.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлын 70 хувиар буюу 22.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,349.6 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	125,694.9	3,809,313.0	3,683,618.1
Авлага	814,131.6	1,635,108.0	820,976.4
Бараа материал	-	1,188.0	1,188.0
Бусад эргэлтийн хөрөнгө	13,607,395.4	11,452,772.0	(2,154,623.4)
Үндсэн хөрөнгө	9,386.1	7,841.8	(1,544.3)
Нийт хөрөнгө	14,556,608.0	16,906,222.8	2,349,614.8
Өр төлбөр	713,290.5	3,446,805.0	2,733,514.5
Засгийн газрын хувь оролцоо	13,843,317.5	13,459,417.8	(383,899.7)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,556,608.0	16,906,222.8	2,349,614.8

Эх сурвалж: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө 3,683.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд урд онуудаас аж ахуйн нэгж байгууллагуудаас татварын дараах ашгийн 3 хувийг татан төвлөрүүлсэн, урьдчилж орсон орлогоос шалтгаалсан;`
- Авлага өмнөх оноос 820.9 сая төгрөгөөр өссөн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч 45 аж ахуй нэгж, байгууллагатай хөрөнгө төвлөрүүлэхээр тооцоо нийлж, авлага үүссэн;
- Тайлант онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гэрээний барьцаа хөрөнгө байршуулснаас шалтгаалан өр төлбөрийн дансны үлдэгдэл оны эхнээс 235.4 сая, салбарын зарим байгууллага Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төвлөрүүлэх 2022 оны шилжүүлгийг урьдчилж хийснээс урьдчилж орсон орлого 2,498.1 сая төгрөгөөр өссөн;
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны бууралт нь өмнө жилүүдэд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон 1,213.3 сая төгрөгийн зардлыг ТӨБЗГ-ын 2021 оны 136 дугаар тогтоолоор, 3,973.5 сая төгрөгийн зардлыг ХХМТГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 04 дүгээр хурлын шийдвэрийн дагуу зардлыг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,264,446.8	5,039,178.5	1,774,731.7
Бусад орлого	50.0	0	(50.0)
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,120.0	1,120.0
Үйл ажиллагааны орлого	**3,264,496.8**	**5,040,298.5**	**1,775,801.7**
Бараа, ажил үйлчилгээний зардал	256,423.9	231,349.5	(25,074.4)
Урсгал шилжүүлэг	5,500.0	6,049.1	549.1
Үйл ажиллагааны зардал	**261,923.9**	**237,398.6**	**(24,525.3)**

Эх сурвалж: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 1,774.7 сая төгрөгөөр буюу 54.4 хувиар өсөлтөд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих, мэдээллээр хангах ажлуудын үр дүнд тайлант онд 45 байгууллагатай тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийн 3,932.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлэхээр төсөвлөсөн байна. Үүнээс төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд 3,681.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд 250.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн төлөвлөгөөг үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,932.0 сая төгрөгийг төвлөрүүлж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд 3,681.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд 250.4 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр 6,750.8 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 233.8 сая, урсгал шилжүүлэгт 4.9 сая, төсөл, арга хэмжээнд зориулан 2,906.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71302	Үндсэн үйл ажиллагаа	250,464.8	238,699.7	11,765.1	95.3
		Алслагдсан орон нутагт хүргэх	3,681,583.6	2,906,574.1	775,009.5	78.9
Нийт дүн			**3,932,048.4**	**3,145,273.8**	**786,774.6**	

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны "Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, ажил хүлээлцэх тухай" Б/02 дугаар тушаалаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албыг татан буулгаж, сангийн үйл ажиллагааг Цахим хөгжил, харилцаа холбооны яам хариуцан зохион байгуулж, ажиллахаар болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч 1,036 байгууллагаас тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 642 байгууллага байна. Тайлант онд 118 байгууллагатай тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн ба бусад 524 байгууллагаас хөрөнгө төвлөрүүлээгүй байна. Мөн Бүх нийтийн үүргийн сангийн үйл ажиллагаа нэгдсэн бодлого, менежментийн төлөвлөгөөгүйгээр хэрэгжиж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан шилэн дансны цахим хуудаст тайлант онд мэдээлэх 114 мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөл, арга хэмжээнд зориулан зарцуулах 3,681.6 сая төгрөгийг төсвийн төслийн саналд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэж тусгаснаас зардлын ангилал буруу батлагдаж, зарцуулалт гарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн саналыг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журамд нийцүүлэн боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх талаар албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд өгсөн албан шаардлагын биелэлтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 47.2 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	9,857.9	1	4,649.4	2	5,208.5	47.2
Нийт дүн	**3**	**9,857.9**	**1**	**4,649.4**	**2**	**5,208.5**	**47.2**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн хэрэгжиж, дууссан төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх 1 албан шаардлагын биелэлт 53.8 хувь, төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх 9.9 сая төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдуулаагүй зөрчилд өгсөн 1 албан шаардлага хэрэгжээгүй, ажлын албыг татан буулгах талаар өгсөн 1 албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд ажлын албанд зориулан 191.4 сая төгрөгийн цалин, НДШ-д зарцуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,138.9 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 5,192.7 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 31.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 915.0 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүллээ.

Залруулаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 946.2 сая төгрөг нь бидний тогтоосон 32.6 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалтай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Өмнөх үеийн үр дүнтэй холбоотой гарсан 5,186.8 сая төгрөгийн зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн;
- Захиалагчийн хяналтын 5.9 сая төгрөгийн зардлыг хувийн хэвшилд олгох татаас /212201/ дансанд бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Хэрэгжиж дууссан, төлбөрийн тооцоог бүрэн барагдуулсан төсөл, хөтөлбөрийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 31.2 сая төгрөг мөнгөн хөрөнгийн дансанд байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тайлант онд сангийн ажлын албаны ажилчдад 4.9 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч 1,036 байгууллагаас тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 642 байгууллага байна. Тайлант онд 118 байгууллагатай тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан эх үүсвэр болон харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ” гэж заасныг зөрчсөн, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх байгууллагатай тооцоо нийлж, сангийн хөрөнгийн төвлөрүүлэлтэд анхаарч ажиллах талаар албан шаардлага өгөв.

Авлагын дансанд 4-5 жилийн насжилттай 176.5 сая төгрөгийн, тооцоо нийлээгүй 106 байгууллагын 572.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацаа үйлчилнэ:”, 75.2.1 “гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж,

үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага өгөв.

Тайлант онд 118 байгууллагаас 15 байгууллага хугацаандаа, 103 байгууллага хуульд заасан хугацаа хоцроон орлогоо төвлөрүүлсэн байна.

Энэ нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын 6.5 "Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд татварын тайлангаа харьяалах татварын болон санхүүгийн албаар баталгаажуулсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ журмын хавсралт маягтыг бөглөж, татварын болон санхүүгийн тайлангийн хамт төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тухайн жилд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг баталгаажуулна", 6.6 "Энэ журмын 6.5-д заасны дагуу баталгаажуулсан хөрөнгийг 30 хоногт багтаан Төрийн санд байрших "Бүх нийтийн үүргийн сан"-гийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй тооцоо нийлж, орлого төвлөрүүлэхэд анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдлээс 84 байгууллагын 161.1 сая төгрөгийг тооцоо нийлээгүй, тайлант жилийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого хэрэгжсэн үед урьдчилж орсон орлогыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх аудитаар өгсөн төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх 9.9 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлага, хэрэгжиж дуусан төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар өгсөн албан шаардлага, ажлын албыг татан буулгах талаар өгсөн 213.2 сая төгрөгийн албан шаардлага, нийт 9,857.9 сая төгрөгийн 3 албан шаардлагын биелэлт 47.2 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Өмнөх үеийн үр дүнтэй холбогдон гарсан 5,186.8 сая төгрөгийн зардлыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	Залруулга хийв.	1	5,186,799.5	1	5,186,799.5						
2	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Захиалагчийн хяналтын зардлыг хувийн хэвшилд олгох татаас /212201/ дансанд бүртгэсэн байна.	Залруулга хийв.	1	5,877.0	1	5,877.0						
3	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Өмнөх аудитаар өгсөн төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх 9.9 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлага, хэрэгжиж дуусан төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар өгсөн албан шаардлага, ажлын албыг татан буулгах талаар өгсөн 213.2 сая төгрөгийн албан шаардлага, нийт 9,857.9 сая төгрөгийн 3 албан шаардлагын биелэлт 47.2 хувьтай байна.	Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.	1	-					1	-		
4	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Тайлант онд сангийн ажлын албаны ажилчдад нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх.	1	4,929.1					1	4,929.1		

5	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Хэрэгжиж дууссан, төлбөрийн тооцоог бүрэн барагдуулсан төсөл, хөтөлбөрийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл мөнгөн хөрөнгийн дансанд байршиж байна.	Захиалагчийн хяналтын зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх	1	31,241.1			1	31,241.1				
6	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч 1,036 байгууллагаас тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 642 байгууллага байна. Тайлант онд 118 байгууллагатай тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн байна.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх байгууллагатай тооцоо нийлж, сангийн хөрөнгийн төвлөрүүлэлтэд анхаарч ажиллах	1	-					1	-		
7	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Тус байгууллагын авлагын дансанд 4-5 жилийн насжилттай 176.5 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.Тооцоо нийлээгүй 106 байгууллагын 572.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулах.	1	748,950.6					1	748,950.6		
8	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Тайлант онд 118 байгууллагаас хөрөнгө төвлөрүүлснээс 15 байгууллага хугацаандаа орлого төвлөрүүлж, 103 байгууллага хугацаа хоцроосон байна.	Хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй тооцоо нийлж, орлого төвлөрүүлэхэд анхаарч ажиллах	1	-					1			
9	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдлээс 84 байгууллагын 161.1 сая төгрөгийг тооцоо нийлээгүй, тайлант жилийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэгүй байна.	Орлого хэрэгжсэн үед урьдчилж орсон орлогыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж байх.	1	161,134.4					1	161,134.4		
Дүн					**9**	**6,138,931.7**	**2**	**5,192,676.5**	**1**	**31,241.1**	**6**	**915,014.1**	**0**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Шилэн дансны цахим хуудаст тайлант онд мэдээлэх 114 мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх.	1	-							1	-
2	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	АХГ-2022/06/НА-СТА-3ГТС	Төсөл, арга хэмжээнд зориулан зарцуулах 3,681.6 сая төгрөгийг төсвийн саналд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэж тусгаснаас 212201 /Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас/ дансанд төсөв батлагдаж, зарцуулсан байна.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийн саналыг хууль, журмын дагуу боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлэх.	1	3,681,583.6					1	3,681,583.6		
Дүн					**2**	**3,681,583.6**	**0**	**-**	**0**	**-**	**1**	**3,681,583.6**	**1**	**-**
Нийт дүн					**11**	**9,820,515.3**	**2**	**5,192,676.5**	**1**	**31,241.1**	**7**	**4,596,597.7**	**1**	**-**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 141/А0160056 Улаанбаатар хот

АХГ-2022/06/НА-СТА-3ГТ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрэгжиж дуусан, төлбөрийн тооцоог бүрэн барагдуулсан төсөл, хөтөлбөрийн захиалагчийн хяналтын зардлын 31,241,173.66 төгрөгийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийн дансанд байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант жил хэрэгжээгүй арга хэмжээний 31,241,173.66 /Гучин нэгэн сая хоёр зуун дөчин нэгэн мянган нэг зуун далан гурван төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 686/А0160056
АХГ-2022/06/НА-СТА-3ТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 118 байгууллагаас 15 байгууллага хугацаандаа, 103 байгууллага хуульд заасан хугацаа хоцроон орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын 6.5 "Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд татварын тайлангаа харьяалах татварын болон санхүүгийн албаар баталгаажуулсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ журмын хавсралт маягтыг бөглөж, татварын болон санхүүгийн тайлангийн хамт төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тухайн жилд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг баталгаажуулна", 6.6 "Энэ журмын 6.5-д заасны дагуу баталгаажуулсан хөрөнгийг 30 хоногт багтаан Төрийн санд байрших "Бүх нийтийн үүргийн сан"-гийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй тооцоо нийлж, орлого төвлөрүүлэхэд анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 687/А0160056 Улаанбаатар хот

АХГ- 2022/06/НА-СТА-3РТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сангийн ажлын албаны ажилчдад 4,929,074.00 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс тэтгэмж, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР — А.ДАВААДОРЖ

АУДИТОР — С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 688/А0160056 Улаанбаатар хот
АХГ-2022/06/НА-СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч 1,036 байгууллагаас тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 642 байгууллага байна. Тайлант онд 118 байгууллагатай тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан эх үүсвэр болон харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх байгууллагатай тооцоо нийлж, сангийн хөрөнгийн төвлөрүүлэлтэд анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 689/А0160056 Улаанбаатар хот

АХГ-2022/06/НА-СТА-3ТТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансанд 4-5 жилийн насжилттай 176,487,849.91 төгрөгийн, тооцоо нийлээгүй 106 байгууллагын 572,462,792.22 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацаа үйлчилнэ:", 75.2.1 "гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 690/АД160056 Улаанбаатар хот

АХТ-2022/06/НА-СТА-ЗРТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдлээс 84 байгууллагын 161,134,396.34 төгрөгийг тооцоо нийлээгүй, тайлант жилийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлого хэрэгжсэн үед урьдчилж орсон орлогыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

9006109
90191203 96

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 691/А0160056 Улаанбаатар хот
АХГ-2022/06/НА-СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт, хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх, ажлын албыг татан буулгах талаар өгсөн албан шаардлагын биелэлт 47.2 хувьтай байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР	А.ДАВААДОРЖ
АУДИТОР	С.АЛТАНХУЯГ

9006109
90191120596

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 692/А0160056
АХГ-2022/06/НА-СА-3ГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл, арга хэмжээнд зарцуулах 3,681,583,600.00 төгрөгийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэж төсвийн төслийг боловсруулан, саналыг хүргүүлснээс шалтгаалан, төсвийн зардлын ангилал буруу батлагдаж, зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн саналыг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журамд нийцүүлэн боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР — А.ДАВААДОРЖ

АУДИТОР — С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ